



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/290

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсгүүд, Төсвийн тухай хуулийн 41.2.2 дахь заалт, УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоол, Засаг даргын удирдлагын зөвлөлийн 2026 оны 08 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөнбулаг сумын хүнсний үйл ажиллагаа эрхлэгчдэд "Хүнсний аюулгүй байдал, дотоод хяналт" сургалтыг зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 2.920.000 (хоёр сая есөн зуун хорин мянга) төгрөгийг гаргахыг Засаг даргын тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг), Бүс, орон нутаг, хөрөнгө оруулалт,бодлого төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны
 05 дугаар сарын 4-ны өдрийн 11 дүгээр
 захирамжийн хавсралт

	Зардлын нэр	Хэмжих нэгж	Мөнгөн дүн	Нийт
Сургагч багш				
1	Улаанбаатараас ирж, буцах зардал	2 тал	88000	176000
2	Сургалтын төлбөр	5 цаг	-	1.150.000
3	Цайны материал	100 хүн	4500	450000
4	Сургалтын хэрэглэгдэхүүн /Дэвтэр, бал/	100 хүн	5000	500000
Бичиг хэрэг				
1	Стенд, баннер хийлгэх	10 ширхэг	40000	400000
2	Бичгийн цаас /гарын авлага, зөвлөмж/	5 боодол	20000	100000
3	Өнгөт принтерийн цэнэглэгч хор	24 ширхэг	6000	144000
	Нийт			2.920.000

_ оОо _

